

"Өргөн нэвтрүүлгийн нэр томъёоны стандарт-Хөтөлбөр" стандартын төсөлд холбогдох

байгууллагуудаас ирүүлсэн саналын товчоо

№	Санал ирүүлсэн байгууллага	Саналын агуулга	Саналыг төсөлд тусгасан байдал
1	МУИС Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхим багш, доктор Т.ӨНӨРСАЙХАН	"Нэр томъёо" жагсаалтын "4. Анги-Цуврал нэвтрүүлэг, киноны дараалж гарах дугаар" гэжээ. Сэтгүүл зүйд нэвтрүүлгийг ангиар хуваадаггүй. Анги бол ерөнхийдөө кино бүтээлд гардаг. Тухайн сэдвийг цааш үргэлжлүүлэн хэд хэдэн зохиол болгох, эсвэл нэг зохиолыг цуврал болгож үйл явдлын чиг баримжаагаар нь хуваахыг хэлдэг.	Тайлбарт нэвтрүүлэг гэснийг хассан.
2		"Аннотация-Нэвтрүүлгийн зохиол" гэжээ. Задалсан тайлбар нь зөв боловч нэвтрүүлгийн зохиол гэж монголоор оноосон нэр нь зөрчилдөөнтэй болжээ. Нэвтрүүлгийн зохиол гэж бүрэн хэмжээний нэвтрүүлгийн эх бичвэрийг хэлдэг. Аннотац бол Нэвтрүүлгийн зохиолын товч танилцуулга. /Аннотация-орос хэлний хувилбарыг ашигласан байна. Монгол хэлэнд орос хэлний ия-төгсгөлийг яах тухай дүрэм бий/	Сэтгүүл зүйн холбогдолтой нэр томъёог оруулахгүй байхаар шийдэж, хассан.
3		Жагсаалтын "8. Арилжаа сурталчилгааны нэвтрүүлэг" гэсэн хэсэгт COMMERCIAL PROGRAMM гэсэн англи үгийг утгачлан дөхүүлжээ. Яахав, ерөнхийдөө байж болох талтай. Гэтэл одоо энэ нэр томъёо олон улсад ерөнхийдөө infomercial гэсэн нэрээр хэрэглэгдэж байгаа. Нөгөө талаар, тайлбарт "газар дээрээс нь сурталчилж" гэжээ. Гэтэл энэ төрлийн нэвтрүүлгийг телевизийн студид ч хийж болдог. Агуулга, хэлбэрийн зөрчил энэ тайлбарт байна. Хүлээн авагчийн хувьд "буйдан дээрх худалдаа" гэсэн дэлхий нийтийн томъёолол ч бий. Мөн энэ тайлбарт "бизнес мэдээ" гэжээ. "Бизнес мэдээ" гэж олон улсын стандартаар ажил хэргийн, эдийн засгийн мэдээг хэлдэг. Ийм төрөл зүйл сэтгүүл зүйд хаана ч байхгүй. Яагаад ийм нэршил манайд үүссэн бэ гэвэл, 2003 оны үед "TV5" телевиз байгуулагдаад удаагүй байхад мэдээг төлбөртэйгээр бичиж, байгууллагын тодорхой орлогыг бүрдүүлж байсан. Төлбөрт мэдээ эхэллээ гэж лид уншихад сонсголонгүй, онцгүй байсан учраас тухайн үед "Цаг" хөтөлбөрийн найруулагчаар ажиллаж байсан хүн "Бизнес мэдээ" гэвэл арай дээр	Англи нэршлийг Infomercial гэж оруулсан ба тайлбарыг өөрчилсөн.

	сонсогдоно гэж санал гарган байгууллага дэмжиж, улмаар энэ төрлийн толгойн шторк анх хийж байсан юм. Яваандаа бусад арилжааны телевизүүд албан бус энэ нэршлийг ашиглах болсон. Тиймээс “бизнес мэдээ” гэсэн сэтгүүл зүйг үл хүндэтгэсэн энэ томьёоллыг ашиглахгүй байхыг хүсье! Бизнесийн мэдээг ажил хэрэг /business news/, эсвэл эдийн засгийн мэдээний талаар ярихад ашиглагдах томьёолол юм. Нөгөө талаар “Бизнес пиар мэдээлэл” байж болно. Энэ нь төлбөрт мэдээний арай дөхүү хувилбар. Гэхдээ манайх шиг худалдан аваарай гэж шууд тулгах бус далд сурталчилгааны агуулга бүхий пиарын үйл ажиллагаа юм.	
	Жагсаалтын “12.Баримтат мэдээ/ гэрчлэх мэдээ/ Баримтат үйл явдлын мэдээ, мэдээллийг газар дээрээс нь сурвалжлан бэлтгэсэн мэдээ. Eyewitness news” гэдэг зүйлийн талаар оруулжээ. Сэтгүүл зүй тэр чигээрээ баримт, эх сурвалж. Баримтгүй бол угаасаа мэдээ биш. “Баримтат мэдээ” гэсэн төрөл зүйл сэтгүүл зүйд байдаггүй, байх ч боломжгүй. Логикийн хууль зөрчсөн ийм нэршил, хаана, хэзээ, хэн ашиглаж байгааг бид мэдэхгүй байна! Мэдээний талаар доктор М. Зулькафилийн “Сэтгүүл зүйн тайлбар толь” номноос харна уу!	Энэ нэр томъёог шаардлагагүй гэж үзээд хассан.
	Жагсаалтын “25. Инфотейнмент-мэдээллийг цэнгээнт төрөлтэй хослуулан хүргэхийг хэлнэ. Infotainment” гэсэн томьёолол оржээ. Тайлбар утгын хувьд маш ядмаг, бодит байдлаас алс юм. Та бүхнийг энэ талаар бодит тайлбарыг “Телевизийн сэтгүүл зүй: түүх, онол, практик. Ред. Доктор М. Зулькафиль. УБ., 2018”, “Мэргэжлийн телевиз. Доктор Г.Мэндхүү, доктор Т. Өнөрсайхан. УБ.,2015” номоос уншихыг зөвлөж байна.	Зөвлөсөн номоос уншиж судлан тайлбарыг илүү дэлгэрүүлж бичсэн.
	Жагсаалтын “29. Контент” гэсэн томьёоллыг ашиглажээ. Контент нь бүтээл юм. Нэгэнт монгол нэр томъёоны тайлбар гаргах гэж байгаа бол агуулгын хувьд хөрвүүлж болох үгийг зохих хувилбараар нь ашиглах нь зүйтэй байх. Сэтгүүл зүйн судлаач, эрдэмтдийн хүрээнд контент гэдэг үгийг бүтээл гэж хэрэглэдэг.	Контент гэсэн хэллэг практикт өргөн хэрэглэгдэж байгаа. Гэхдээ “бүтээл” гэж нэрлэх хувилбараар дахин санал авч байгаа.
	Жагсаалтын “31. Мэдээний толгой – мэдээний гарчиг-тухайн мэдээний талаарх урьдчилсан ойлголтыг өгөх товч ишлэл үг, өгүүлбэрийг хэлнэ. Headline” гэжээ. Хоорондоо зөрүүтэй ойлголтуудыг хольж хутгасан байна. Мэдээний толгой –лид, мэдээний гарчиг хоорондоо ялгаатай ойлголтууд. Энэ талаар та бүхэн доктор Ч. Чойсамбын “Монгол сонины мэдээ”, “Сонины хэл	Сэтгүүл зүйн холбогдолтой нэр томъёог оруулахгүй байхаар шийдэж, хассан.

		найруулга”, доктор М.Зулькафилийн “Сэтгүүл зүйн тайлбар толь”-с дэлгэрүүлж харна уу!	
		Жагсаалтын “34. Нийтлэл-Нийгэмд болж байгаа нийтлэг/өдөр тутмын үйл явдлын талаарх нэвтрүүлэг” гэж тайлбар бичжээ. Бүтээл телевиз дээр ирэхээрээ нийтлэг нэршил нь нэвтрүүлэг болдог, тогтмол хэвлэлд очихоороо нийтлэг нэр нь нийтлэл болдог. Мөн нийтлэл зүй /publication/ гэсэн төрөл бий. Телевизэд теленийтлэл гэсэн хувилбар бий. Тогтмол хэвлэлийн бичвэр эхлээд радиод очиж, дараа нь телевизэд радиогоос очихдоо хэрэгслийн онцлогийг тусган өөрийн өвөрмөц шинж чанараар биежэж, боловсронгуй болсон. Энэ тохиолдолд теле нийтлэл гэсэн нэр томъёлол байж болно. Та бүхэн нийтлэл-publication-ий талаар доктор М.Зулькафилийн “Сэтгүүл зүйн тайлбар толь” номоос харна уу! Мөн энэ хүний орчуулсан “Нийтлэл, нэвтрүүлгийг хэрхэн бэлдэх вэ?” номонд ялгааг нь гаргасан байгаа.	Сэтгүүл зүйн холбогдолтой нэр томъёог оруулахгүй байхаар шийдэж, хассан.
		Жагсаалт “35. Нөхөөс хөтөлбөр” гэсэн хэсэг оруулжээ. “Хөтөлбөрийн цагийн хуваарьт заасан нэвтрүүлэг хооронд гарсан хоосон цагийг нөхөж оруулах богино хэмжээний хөтөлбөрийг хэлнэ. Ийм төрлийн хөтөлбөрийн үргэлжлэх хугацаа 30 минутаас хэтрэхгүй байна” гэж тайлбарласан байна. Нэгдүгээрт, нөхөөс хөтөлбөр телевизэд байх ёстой юу, хоёрдугаарт хөтөлбөр гэж юу вэ гэдэгт эргэлзээтэй зөрчлүүд байна. Телевизийн хөтөлбөр буюу нэвтрүүлгийн сүлжээ /уг нь мэргэжлийн тогтсон нэршил/ ерөнхийдөө бүтцийн хувьд 10 гаруй төрөл байдаг. Манайд МҮОНТ-ийн хуучин 1967 оноос хойш хэрэглэж ирсэн ганцхан хувилбарыг л хэрэглэдэг. Сүүлийн үед ганц хоёр телевиз өөр хувилбар ашиглах болсон нь сайшаалтай. Нэвтрүүлгийн сүлжээ боловсруулах стратеги гэж бий. Энэ стратегиар бол сүлжээ хоорондоо огт зайгүй өрөгдсөн байх ёстой. Тэгэхээр энэ “Нөхөөс хөтөлбөр” гэдэг зүйл албан ёсоор нэршээд байдаг болчихвол телевизийн нэвтрүүлгийн сүлжээ зохиох хэрэг ер нь байна уу! 30, 30-н минутаар нөхөөс тавиад явчихъя! “Нөхөөс хөтөлбөр” гэдэг юм телевизийн сэтгүүл зүйд байдаггүй. Тэр тусмаа 30 минут гэдэг телевизийн хувьд асар их, маш их цаг хугацаа. Нэвтрүүлгийн сүлжээний стратегийн дагуу тухайн цаг мөчид эрсдэлтэй зүйл үүссэн бол асуудлыг шийдэх аргачлалын дагуу явна уу гэхээс “нөхөөс хөтөлбөр” тавина гэж суух ямар ч олон улсын телевиз байхгүй.	“Нөхөөс бичлэг” гэж өөрчлөн нэрлээд тайлбарыг “Телевизийн хөтөлбөрийн цагийн хуваарьт заасан үндсэн нэвтрүүлэг хооронд гарсан цагийг нөхөж оруулдаг зураглал, телевизийн танилцуулга зэрэг богино хэмжээний бичлэг” гэж өөрчилсөн.

		Нөгөө талаар “хөтөлбөр” гэдэг үг. Хөтөлбөр бол олон зүйл нэгдэж нийлсэн цул зүйл. Тэгэхээр “нөхөөс хөтөлбөр” гэхээр бүр хөтөлбөрийн хэмжээнд нөхөөс тавьж болно гэсэн үг болж байна. Энэ чинь телевизийн мөн чанарыг зөрчиж байна.	
		Жагсаалтын “37. Нэвтрүүлгийн пром” гэж томъёолол оржээ. Энд мөн л эх сайхан монгол хэлээ ашиглацгаая. Нэвтрүүлгийн товч танилцуулга. Дээр дурдагдсан аннотац бол нэвтрүүлгийн зохиолын товч танилцуулга. Харин пром бол нэгэнт дүрсжүүлсэн бэлэн нэвтрүүлгийн товч танилцуулга юм. Үүгээрээ ялгаатай.	Саналыг тусган “Нэвтрүүлгийн товч танилцуулга” гэж нэрлэсэн.
		Жагсаалтын “39. Олон талт хөтөлбөртэй телевиз /ерөнхий/-хөтөлбөрийн бодлогын хувьд олон төрөл, чиглэлтэй телевизийг хэлнэ. Хөтөлбөр бүхэлдээ болон хөтөлбөрийн дийлэнх нь олон талт байх боломжтой. Олон талт хөтөлбөртэй телевизэд төлбөртэй телевиз хамаарахгүй бөгөөд зөвхөн зар сурталчилгааны орлогоор санхүүжих телевизийг ойлгоно-general channel-generalist” гэсэн зүйл оржээ. Нэг дэх бодомж: Олон талт хөтөлбөртэй телевиз гэж юуг хэлээд байна аа? Хөтөлбөр бол нэвтрүүлгийн сүлжээ. Тэгэхээр энэ нэршил дээр үндэслээд бодох юм бол Нэвтрүүлгийн сүлжээндээ бүх төрөл зүйлийн бүтээлийг багтаасан болж таарах нь. Тэгвэл энэ чинь олон нийтийн телевиз л байж таарна. Эсвэл орон даяар цацагдах эрх бүхий бүх талын бүтээлийг харуулах үүрэг /албан ёсоор хүлээсэн/ бүхий арилжааны телевиз байх ёстой. Манайд одоо үйл ажиллагаа явуулж буй, орон даяар цацагдаж байгаа арилжааны телевизүүдийн хувьд ийм /олон улсын хэв шинжээр харвал/ ийм чадамж, боломж байхгүй. Орон даяар цацагдах арилжааны телевизийн /ийм тохиолдолд өмчийн хувьд улсын оролцоо, эсвэл олон нийтийн оролцоо тодорхой хувьд нь заавал байх ёстой- эрх үүргийг нь тэнцвэржүүлэх үүднээс- олон улсын практик. / хувьд нэг эзний нэг группийн мэдлийнх байх боломжгүй. Өмчийн хосолмол төрөл байх учиртай. Хоёр дахь бодомж: “Олон талт хөтөлбөртэй телевизэд төлбөртэй телевиз хамаарахгүй бөгөөд зөвхөн зар сурталчилгааны орлогоор санхүүжих телевизийг ойлгоно” гэжээ. Мэдээж төлбөртэй телевиз буюу pay tv- ганцхан чиглэлээр дагнаж байж л төлбөр мөнгөө олно	Энэ нэр томъёог шаардлагагүй гэж үзээд хассан.

	<p>шүү дээ.! Нөгөө талаар, энэ тохиолдолд дээд талын олон талт хөтөлбөртэй байх буюу олон нийтийн телевизийн хэв шинжийг агуулна гэсэн мөртлөө зөвхөн зар сурталчилгааны орлогоор санхүүжинэ гэжээ. Маш том логик зөрчилтэй байна. General channel- гэдэг үгийг гүжирдэж орчуулснаас ийм байдал үүссэн бололтой. General channel- гэж телевизийн хэд хэдэн сувагтай тухайлбал, "boxnetwok" суваг телевизүүдтэй байлаа гэхэд арилжааны өргөн нэвтрүүлгийн телевизийн эрх эдэлж байгаа тохиолдолд тухайн корпорацийн хувьд мэдээ явдаг арилжааны өргөн нэвтрүүлэг нь general channel болно. Эсвэл улс даяар монополь тогтоосон улсын дэмжлэгтэй ОХУ-ын Первый канал, РТР, БНХАУ-ын CCTV general channel болдог. Манайд байх боломжгүй. Ойлголтын зөрүү гарсан байна.</p>	
	<p>Жагсаалтын "42. Оройн цаг –Evening hours" гэсэн томъёолол байна. Гэтэл тайлбарыг нь уншихаар "Оргил цаг"-ийн тухай бичжээ. Маш том зөрүүтэй хоёр ойлголтууыг хольж хутгасан байна. Телевизэд өглөөний болон оройн оргил цаг гэж байдаг. "МУИС-ийн "Сэтгүүл зүй" эрдэм шинжилгээний бичиг 2013" дугаарыг уншиж, оргил цагийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл авна уу!</p> <p>Тайлбар дээр нь "Оргил цаг"-ийн тухай мөртлөө нэрийн томъёолол нь ХӨТӨЛБӨР-ийн тухай байна. Телевизэд өглөө, өдөр, орой буюу үзэгчийн зан төлөв, боломжит болон болзолт хүлээн авагчийн амьдралын хэмнэлтэй зохицсон breakfast tv, day tv, evening tv гэсэн хөтөлбөрийн хувилбар байдаг. Телевизийн тухай А-Я хүртэл номонд энэ талаар бий. Тэндээс дэлгэрүүлж харна уу!</p>	<p>Энэ нэр томъёог шаардлагагүй гэж үзээд хассан.</p>
	<p>Жагсаалтын "49.Сурвалжлагч" гэсэн хэсэгт огт буруу, маш буруу тайлбар хийсэн байна. Доктор М. Зулькафилийн "Сэтгүүл зүйн тайлбар толь"-с дэлгэрүүлж харна уу!</p>	<p>"Телевизийн тухай А-Я хүртэл" номоос авч засаж оруулсан. "Сэтгүүл зүйн тайлбар толь" номонд Сурвалжлага гэдгийг тайлбарласныг уншиж судалсан.</p>
	<p>Жагсаалтын "57.Үзэгчийн зан төлөв" мөн л буруу тайлбартай. "Телевизийн сэтгүүл зүй: түүх, онол, практик" номноос харна уу!</p>	<p>Заасан номыг үзсэн ба тайлбарыг засаж бичсэн.</p>
	<p>Жагсаалтын "61. Холбоос реклам" буруу тайлбар, нэршилтэй.</p>	

		Жагсаалтын “63. хөтлөгч” буруу тайлбартай, ойлголтын зөрүүтэй	“Телевизийн тухай А-Я хүртэл” номоос авч оруулсан.
		Жагсаалтын “64. Хөтөлбөрийн промо танилцуулга”- Хөтөлбөрийн танилцуулга –Нэвтрүүлгийн сүлжээний танилцуулга	Хөтөлбөрийн танилцуулга гэж оруулсан
		Жагсаалтын “65. Хөтөлбөрийн төрөл /формат, хэлбэр Хөтөлбөрийн бодлогын дагуу тодорхойлсон ерөнхий чиглэл /Кино, мэдээ, хөгжим, спорт гэх мэт/” А. Маш зөрүүтэй тайлбар байна. Телевизийн нэвтрүүлэг, хөтөлбөр гэдэг хоёр үгний ялгааг эхлээд тайлбарлах хэрэгтэй. Б. Төрөл зүйл гэдэг чинь хоёр өөр ойлголт. Телевизийн бүтээлүүд агуулгын болон хэлбэрийн хувьд ангилагддаг. Агуулгын хувьд сэтгүүл зүйн бичлэгийн төрөл зүйлээр, хэлбэрийн хувьд дүрсэн өгүүлэмжид тулгуурласан өгөгдлийн хэв шинжээр ангилна. Ийм том ойлголтыг ТӨРӨЛ гэж тодорхойлох нь явцуу юм.	Нэвтрүүлгийн формат, Төрөл жанр гэдэг үг хэллэг ашигласан. Хөтөлбөрийн төрөл гэснийг хассан.
		Жагсаалтын “66. Худалдан авалтын хувь –Төлбөрт үзэлттэй ТВ-ээс /pay-per-view TV/ нэвтрүүлэг худалдаж авсан хэрэглэгчийн хувь-Buy gate” гэжээ. pay-per-view TV буюу тухайлсан хөтөлбөрийг төлбөртэй үзэх эрх гэдгийг ойлгож байна. Гэтэл худалдан авалтын хувь гэдгийг юу гэж ойлгох вэ? Хэтэрхий гүжирдсэн орчуулга бус уу!	Энэ нэр томъёо шаардлагагүй гэж үзээд хассан
		Жагсаалтын “70. Цаг үеийн мэдээний хөтөлбөр-ИИМ НЭРШИЛ БАЙХГҮЙ, БАЙХ БОЛОМЖГҮЙ. А. Мэдээ юм чинь цаг үеийнх нь байх нь ойлгомжтой. Тийм учраас монгол хэлний онцлог, сэтгүүл зүйн үг хэмнэх зарчмаар “Мэдээллийн хөтөлбөр” гэж нэрлэдэг. /мэргэжлийн олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн томъёолол/. Б. “Мэдээний хөтөлбөр” гэж байхгүй. Мэдээ гэдэг бол сэтгүүл зүйн мэдээлсэн бичлэгийн төрлийн мэдээ гэх зүйлд хамаарах нэгж бичвэр. Хөтөлбөр гэж байгаа юм чинь олон зүйл дотор нь байх нь ээ дээ. Тийм учраас ганц дан мэдээ яваад байвал хөтөлбөр болохгүй. Тэр хөтөлбөрт чинь мэдээ, сурвалжлага, тайлан, тойм, ярилцлага гээд Мэдээлсэн бичлэгийн төрөлд багтах маш олон зүйлийн бичвэр орно. Тиймээс мэдээлсэн бичлэгийн төрлийн зүйлүүдийг багтаасан учраас	Мэдээ, Мэдээллийн хөтөлбөр гэсэн үг хэллэгүүд орсон ба Цаг үеийн мэдээний хөтөлбөр гэснийг хассан.

	<p>Мэдээллийн хөтөлбөр гэдэг. Энэ талаар доктор, профессор Л. Норовсүрэнгийн “сэтгүүл зүйн бичлэгийн төрөл зүйл” номыг харна уу! Мөн энэ хэсэгт “Цаг үеийн шинж чанартай, өдөр тутмын, нийгэмд болж буй үйл явдлын талаарх сурвалжлага, мэдээг хөтлөгчийн хөтлөлттэй хүргэхийг хэлнэ” гэжээ. Агуулгын хувьд ч хэлбэрийн хувьд ч маш зөрчилтэй. Үг сонголтын хувьд ч “ядуу” болжээ. Hard news- гэж англи томъёоллыг нь дүйцүүлсэн байна. БУРУУ. Ерөнхийдөө HARD NEWS гэж манайхны протокол гэж нэрлээд байдаг байнга болж байдаг, албаны мэдээг хэлдэг мэргэжлийн жаргон. HARD NEWS-ийг мэдээллийн хөтөлбөр гэж ойлгуулж дүйцүүлэх нь үнэхээр том алдаа болно.</p>	
	<p>Жагсаалт “71. Цэнгээнт” хэлбэрийн ангиллаас ганц орсон нь. Бусад нь огт байхгүй мөртлөө энэ ганцаараа “цохиж” явдаг. Мөн тайлбар нь дутуу.</p>	
	<p>Жагсаалтын “72. Чиглэсэн харц” хөтлөгч-камер-дэлгэцийн харьцааг илэрхийлэх гэсэн бололтой. Тайлбар учир дутагдалтай.</p>	<p>Шаардлагагүй гэж үзээд хассан</p>
	<p>Жагсаалтын “73. Шилжилтийн хугацаа” яг аль шилжилтийн хугацааг томъёолох гэсэн нь тодорхойгүй. Тайлбарыг уншихаар техникийн хэв шинжийг бичжээ. Мөн шилжилтийн хугацаа гэж эвлүүлэгт байдаг. Дүрс шилжих хугацаа гэж.</p>	<p>Нэршлийг аналог тоон шилжилт гэж өөрчилсөн</p>
	<p>Жагсаалтын “74. Шторк. Тайлбарын зөрүүтэй. Шторк гэж эвлүүлгийн нэг хэлбэр. /Wire/. Тасалсан дүрс, шахаж багасгасан хэсэг. Телевизийнхэн хоорондоо шторк гэж ярьдаг учраас оруулсан бололтой. Тайлбартайгаа нэршил нь зөрчилдөж байна.</p>	<p>Зар сурталчилгаа гэсэн нэршлээр орсон. Шторк гэснийг хассан.</p>
	<p>Телевиз бол Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл-Олон нийтийн харилцаа юм. Техник технологи, маркетинг мөнгө, кино урлаг бол зүгээр л энэ харилцааг хангагч бүрдүүлэгч жижиг хэсгүүд нь. Тиймээс Сэтгүүл зүйг барьж энэ төслийг боловсруулах нь зүйтэй.</p>	<p>Стандартын хамрах хүрээг Өргөн нэвтрүүлгийн чиглэлийн ерөнхий үг хэллэгүүд, хэрэглэгчийн үйлчилгээнүүд, ялангуяа шинээр гарч ирж буй үйлчилгээнүүд болон зар сурталчилгаа, өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдийн бизнес харилцаатай холбоотой үг</p>

			хэллэгүүдийг багтаасан байхаар хязгаарласан. Өргөн нэвтрүүлгийн байгууллагуудын зөвхөн дотоодын үйл ажиллагаандаа ашигладаг болон сэтгүүл зүйн холбогдолтой мэргэжлийн үг хэллэгүүдийг оруулахгүй байхаар тогтсон.
		“Өргөн нэвтрүүлгийн нэр томъёоны стандарт-хөтөлбөр” төслийг нэрлэжээ. Агуулгын хувьд зөрчилтэй нэршил байна гэж үзэж байна. Нэгэнт стандарт тогтоох гэж байгаа юм бол –Хөтөлбөр- гэсэн нэмэлт тайлбар ямар холбоотой нь ойлгомжгүй байна. Гэтэл уг хөтөлбөрийнхөө талаар тайлбар нь алга.	Төслийн нэрийг “Өргөн нэвтрүүлгийн нэр томъёоны стандарт- үйлчилгээ” гэж нэрлэх санал гаргасан.
		Үнэхээр тайлбар, томъёоллыг хийх гэж байгаа юм бол логик дараалалтай, бүтцийн хувьд бүрэн байх ёстой. Бүтээлийн агуулга, хэлбэрийн талаар юу ч байхгүй.	Стандартад орсон үгсийг төрөлжүүлж, бүлэглэн хянаж үзсэн.
	МУИС Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхим багш, доктор /Ph.D/ Г.Мэндхүү	Энэ жагсаалт нь монгол хэлний найруулга зүйн хувьд тун болхи байна. Нэр томъёоны тайлбар хийнэ гэдэг эх хэлээр дүйцүүлэн ойлгох тогтсон нэршил, түүний гадаад хувилбар нэршил хоёрын харьцуулалт байдаг. Эх монгол хэлээрээ чухам юуг хэлээд байгаагаа ойлгохгүй байгаа хүн, гадаад утгыг нь “махчилж” /уучлаарай, google translate ашигласан юмуу?/ орчуулсан бололтой.	Шүүмжлэлийг анхаарч, үг, найруулгыг засварлан хичээж бичсэн болно.
		Нэр томъёоны тайлбарыг боловсруулахад шинжлэх ухааны аргачлал байдаг. Ямар ч аргачлалгүй хийсэн нь илэрхий байна. Энэ салбар чиглэлийн мэргэжил эзэмшиж, судалж шинжлэн, практикт ажилласан хүмүүс хийсэн гэдэгт эргэлзэж байна. Сэтгүүл зүйн анхны ойлголттой хүн ядаж л наад зах нь "мэдээ" гэж юу болохыг мэддэг юм. "Мэдээ"-ний дотоод бүтэц, ангилал зэргийг мэдэх учиртай.	Анхааралдаа авсан.
		Сэтгүүл зүй бол ШИНЖЛЭХ УХААН. Шинжлэх ухаанд стандарт тогтоодог болсон юм уу? Хэрвээ дэлхий нийт ШИНЖЛЭХ УХААНД стандарт тогтоодог болсон юм бол шинэ нээлт, туршилт, гаргалгаа, урсгал чиглэл бий болгохын тулд академик түвшний судалгаа хийх хэрэг байна уу?	Стандартын төсөлд сэтгүүл зүйн болон нарийн мэргэжлийн үг хэллэг оруулахгүйгээр зөвхөн хэрэглэгчийн үйлчилгээ,

			бизнес харилцаагаар хязгаарлсан болно.
		“Өргөн нэвтрүүлгийн нэр томъёоны стандарт-Хөтөлбөр” стандартын төсөл мэргэжлийн чанарын шаардлага хангахгүй. Монголын телевизийн сэтгүүл зүйн нэр томъёог бүрэн дүүрэн байтугай илэрхийлэх чадамжгүй болсон байна.	Стандартын төсөлд сэтгүүл зүйн болон нарийн мэргэжлийн үг хэллэг оруулахгүйгээр зөвхөн хэрэглэгчийн үйлчилгээ, бизнес харилцаагаар хязгаарлсан болно.
		Тус стандартыг боловсруулахдаа “Норматив эшлэл” /нэр томъёоны стандарт батлах гэж байгаа юм бол ядаж “норматив” гэдэг үгээ орчуулж болсонгүй юу!/ гэсэн хэсэгт доктор /Ph.D/ Г.Мэндхүү миний хамтран бичсэн “Телевизийн тухай А-Я хүртэл”, “Радиоогийн тухай А-Я” хүртэл номнуудыг ашигласан гэжээ. Гэтэл бодит байдал дээр ганц хоёр хэсэгт л дурдагдсан байна. Үүнийг хүлээж авах мэргэжлийн түвшнийхэн, сэтгүүлчид нөхөр Г.Мэндхүү, Д.Батжаргал, Т.Өнөрсайхан нар ийм шинэ хэв маяг гаргаж гэж ойлгохоор байна. Телевизийн сэтгүүл зүйд агуулга хэлбэрийн зөрчилдөөн үүсгэж, үл тохирсон, мэргэжлийн бус ийм тайлбаруудыг миний бие бичээгүй болно. Тиймээс мэргэжлийн шаардлага хангаагүй стандартын төслийн “Норматив эшлэл” хэсэгт оруулсан “Радиоогийн тухай А-Я хүртэл”, “Телевизийн тухай А-Я хүртэл” номуудыг эх сурвалж болгон ашигласан гэж бичихийг зохиогчийн хувьд хүлээн зөвшөөрөхгүй гэдгээ хариуцлагатайгаар мэдэгдэж байна! Дээрх хоёр номын нэрийг “Норматив эшлэл” хэсгээс хасна уу!	Норматик эшлэл хэсгээс хассан.
	TV9 телевиз	“Өргөн нэвтрүүлгийн нэр томъёо-хөтөлбөр” стандартыг гаргахын өмнө уг сэдвээр нийт телевизийн ажилтнуудын дунд хэлэлцүүлэг явуулж санал авах нь зүйтэй болов уу?	
		Сэтгүүлч мэргэжлээр боловсон хүчин бэлтгэж байгаа арав гаруй их дээд сургуулийн эрдэмтэн судлаачдаас энэ ажилд оролцуулж хамтарсан ажлын хэсэг байгуулан ажиллуулах нь илүү үр дүнтэй болно гэж үзэж байна. Өмнөх он жилүүдийн туршлагаас харахад аль нэгэн шинжлэх ухаан, түүний дотор сэтгүүлзүйн шинжлэх ухаанд хамааралтай асуудлаар станадрт нэр томъёо, хөтөлбөр боловсруулах хэрэгцээ шаардлага гарсан тохиолдолд мэргэжлийн хүмүүс, тухайн салбарын эрдэмтэн мэргэдийн санал бодолд голлон	Стандартын төсөлд сэтгүүл зүйн болон нарийн мэргэжлийн үг хэллэг оруулахгүйгээр зөвхөн хэрэглэгчийн үйлчилгээ, бизнес харилцаагаар хязгаарлсан болно.

		тулгуурладаг, цаг хугацаа гаргаж өгдөг байсан болно. Стандартын төсөл дээр ахин нухацтай сууж ажиллах шаардлагатай санагдав. Үүнийг мэргэжлийн хүмүүсийн оролцоогүйгээр ялангуяа сэтгүүлзүйн салбарын эрдэмтдийн санал бодолд тулгуурлахгүйгээр ХХЗХ дангаараа бие дааж боловсруулах нь учир дутагдалтай болно.	
	ХХМТГ	Нэр томъёог төрлөөр ангилах; Тухайлбал: Хөтөлбөр, Цаг, Зар сурталчилгаа гэх зэргээр...	Төрөлжүүлж, ангилсан.
		Нэр томъёог оновчтой тодорхойлох, давхцуулахгүй байх;	Хянан үзэж, давхцлыг арилгасан болно.
		Тайлбар хэсэгт өмнө нэрлэсэн нэр томъёог дахин өөрөөр нэрлэхгүй байх;	Хянан үзэж, давхцлыг арилгасан болно.
		Нэр томъёоны тайлбарыг нэг хэлбэрээр бичих; Тухайлбал: үйл үгээр төгсгөх, бүтэн өгүүлбэрээр тайлбарлах.	Хянан үзэж, засварласан болно.
		Нэр томъёо № 1. Агаар гэдгийг томъёолох шаардлагагүй юм. Телевизийн өргөн нэвтрүүлэгт агаар гэж нэр томъёо дангаараа хэрэглэгддэггүй. Free to air-ийг томъёолсон байхад хангалттай.	Агаар гэдэг томъёоллыг хассан.
		Нэр томъёо № 2. Агаарын өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ /агаарын төлбөргүй ТВ/ гэдгийг Өргөн нэвтрүүлгийн ангилалтай уялдуулж нэрлэх нь зүйтэй гэж үзэж байна. “Өргөн нэвтрүүлэг” эсвэл “Телевиз” гэж нэрлэх. Учир нь стандарт батлагдсанаар агаарын өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ гэдэг шинэ нэршил гарах магадлалтай байна. Тайлбар хэсгийг “Зохицуулах хорооноос Монголын үндэсний олон нийтийн радио, телевизэд олгосон тусгай зөвшөөрөлтэй телевиз, суваг, радиог тоон телевиз, радиогийн газрын дахин дамжуулах сүлжээгээр радио давтамж ашиглан тодорхой хамрах хүрээнд үзэгчдэд төлбөргүй /Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 17.1.1-д заасан үйлчилгээний хөлс/ хүргэх үйлчилгээ ” гэж өөрчлөх;	“Өргөн нэвтрүүлгийн (төлбөргүй) ТВ” гэж нэрлэсэн. Харин тайлбарыг ерөнхий байдлаар томъёолсон.
		Нэр томъёо № 7. Арилжаа сурталчилгааны мэдээлэл гэдгийг Захиалгат нэвтрүүлэг болгож өөрчлөх. Тайлбар хэсгийг илүү тодорхой болгож найруулах, дамжуулах хугацааг дахин судалж ОУ-ын жишигт болгох;	“Арилжаа сурталчилгааны нэвтрүүлэг/ инфомершиал” гэж нэрлэсэн ба тайлбарыг мөн шинэчилж, хугацаа заасныг хассан.
		Нэр томъёо №8. Тайлбар: Арилжаа, сурталчилгааны нэвтрүүлэг нь захиалгат нэвтрүүлэгтэй харьцуулахад дамжуулах хугацаа бага байдаг. Хугацааг тодорхой бичих;	

		Нэр томьёо №10. Баннерийн стандарт хэмжээ байдаг эсэхийг тодруулах, хэрэв байдаг бол тайлбар хэсэгт оруулах;	Тайлбарт “зохицуулалт, журмаар баннер ашиглан сурталчилгаа гаргах хэм хэмжээг зааж өгсөн байдаг.” гэж нэмж оруулсан.
		Нэр томьёо №15. Дуу дүрст / Дуу дүрсэн - Тайлбар хэсэгт нэр томьёог тайлбарлаж бичих;	Нэр томьёог өөрчилж, тайлбар бичсэн
		Нэр томьёо №19. “ОНМХ” товчилсон нэрийг задалж бичих, тайлбарыг дахин найруулах;	Энэ нэр томьёо шаардлагагүй гэж үзээд хассан.
		Нэр томьёо №20. Зар сурталчилгаа нийлүүлэгч - Зар сурталчилгааг 19-д тодорхойлсон учир тайлбар хэсгийг “Зар сурталчилгааг үзэгчид/хэрэглэгчдэд хүргэж буй байгууллага эсвэл хувь хүн” болгож өөрчлөх;	Энэ нэр томьёо шаардлагагүй гэж үзээд хассан.
		Нэр томьёо №22. “Зар сурталчилгааны хязгаарлалт” гэдгийг “Зар сурталчилгааны хугацаа” болгох; Тайлбар хэсэгт: Цаг тутамд эсвэл эфирийн хоногийн хугацаанд... гэдгийг бүтэн өдөрт болгон өөрчилж 14-тэй уялдуулах;	Саналыг тусгасан.
		Нэр томьёо №23. Зөвхөн зүй бус зар сурталчилгаанаас гадна бусад хууль бус зар сурталчилгаа хамруулах;	Хууль бус зар сурталчилгааг оруулсан.
		Нэр томьёо №24. Тайлбарыг “ Нэвтрүүлгийн эхэнд болон төгсгөлд ивээн тэтгэгчийг зарлах богино зарлал” гэж өөрчлөх;	Саналыг тусгаж, тайлбарыг илүү дэлгэрүүлсэн. “Ивээн тэтгэгчийн сурталчилгаа - Ивээн тэтгэгчтэй радио, телевизийн нэвтрүүлгийн үеэр (эхэнд эсвэл төгсгөлд голдуу) ивээн тэтгэгчийг зарлах (логог дүрсээр харуулах эсвэл нэрлэн дурдах) мэдээлэл.”
		Нэр томьёо №26. Кабелиар дамжуулах - Тайлбарыг “Нэвтрүүлгийг кабелийн дахин дамжуулах сүлжээгээр дамжуулах” гэж өөрчлөх;	Энэ нэр томьёо шаардлагагүй гэж үзээд хассан.

		Нэр томъёо №29. Тайлбарыг “Харилцаа холбооны сүлжээгээр дамжиж буй бүтээлийн шинж чанартай тэмдэгт, дохио, текст, зураг, дуу, авиа, дүрс, бичлэг болон бүх төрлийн мэдээ, мэдээллийг электрон хэлбэрт хувиргасан агуулгыг” гэж өөрчлөх;	Тайлбарыг өөрчилсөн.
		Нэр томъёо №33. Тайлбарыг дахин найруулах; “Телевизийн нэвтрүүлгийг үзэгчдийн нас бүрээр тооцсон ангилал...”	“Телевизийн нэвтрүүлэг үзэх үзэгчдийн насны ялгаагаар тооцсон ангилал Ялангуяа хүүхдэд үзүүлэхэд тохиромжтой эсвэл тохиромжгүй болохыг эцэг эхчүүдэд анхааруулах зорилготой байдаг.” Гэж өөрчлөн найруулсан
	MNBC	Саналгүй	
	МУБСШУЯ	Саналгүй	
	ХХЗХ – А. Лувсан-Очир	Хамрах хүрээний хувьд Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээг дамжуулах үйлчилгээ эрхлэгчдийн талаар яагаад тусгаагүй юм бол оо?	Хамрах хүрээг өөрчилж, зөвхөн хөтөлбөр бэлтгэхтэй холбоотой бус өргөн нэвтрүүлгийн бусад үйлчилгээнүүдийг хамруулсан.
		Нэр томъёоны 2 дахь хэсэг - Агаарын өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ гэж яагаад зөвхөн МNB-г гэж тодорхойлж бичив? Тоон телевиз, радиогийн газрын дахин дамжуулах сүлжээ гэж юу вэ?	Free to air TV нэр томъёог Өргөн нэвтрүүлгийн телевиз гэж нэрлэн, тайлбарыг бүрэн өөрчилсөн.
		4 дэх хэсэг Телевизийн тоон газрын сүлжээ гэж бас юу вэ? Дээрх сүлжээнээс ялгаатай юу эсхүл адилхан уу? Ямар сүлжээг хэлж байна аа. Ижилхэн бол нэр томъёог нэр мөр болгох	“Аналог тоон шилжилт” нэршлийн тайлбарыг шинэчлэн найруулсан.
		9 - хамгийн багадаа болон дундаж хугацааг нь зааж өгсөн хирнээ яагаад хамгийн их хугацааг зааж өгсөнгүй вэ? Агуулгын зөрчилтэй байна. Үг өгүүлбэрийг нь хүн уншиж ойлгохоор тодорхой найруулах.	Нэршлийг “Арилжаа сурталчилгааны нэвтрүүлэг” болгон өөрчилж тайлбарыг найруулж, зассан.
		Төлбөртэй мэдээлэл өгөх хөтөлбөр, Сурталчилгааны дагнасан нэвтрүүлэг 2-ын ялгааг юу гэж ойлгох вэ?	Эдгээр нэршлүүдийг нэгтгэж, “Арилжаа

			сурталчилгааны нэвтрүүлэг” гэдгээр тайлбарласан.
		Ам барилт, аудио барилт 2 чинь технологи юм уу эсхүл үйлдэл юм уу? Технологи бол ямар технологи вэ?	Аудио барилт буюу Audio matching нь ТВ үзэлтийг хэмжихэд ашиглагддаг технологи. Гэхдээ энэ стандартад оруулах шаардлагагүй нийтэд өргөн хэрэглэгдэхгүй юм гэж үзээд хассан. Ам барилт буюу Dubbing нь мөн дотоод үйл ажиллагааны хэллэг гэж үзээд хассан.
		17 - Хуулийн тайлбар хийхгүй ээ. Хэт журмын шинж чанартай болсон байна. Стандартад ашгийн байна уу үгүй байна уу огт хамааралгүй зүйл гэдгийг анхаарах. Стандарт тогтоож байгаа зорилгоосоо хазайсан байна!!!	Хууль, журмын шинж чанартай нэмэлт тайлбарыг хасч, дахин найруулсан.
		18 - Бүтээл үйлдвэрлэлийн 1-р үе шат нь юу ийн?	Энэ нэр томъёоны нэршил, тайлбар эргэлзээтэй байсан тул хассан. Ерөнхий агуулга нь Стуид гэдэг нэрээр орсон.
		20 - Олон сувгийн дамжуулах үйлчилгээ эрхлэх гэж юу ийн? Дээр эхэнд бичсэнээс ямар ялгаатай ийн? Нэр агуулгыг 3 янзаар бичсэн байна!!!	Олон суваг дамжуулах үйлчилгээ (ОСДҮ) гэсэн нэрийг нэр томъёонд нэмж оруулан тайлбар хийсэн ба бусад тайлбарт энэ нэрийг ашигласан.
		27 - гм - гэх мэт гэдгийг тодорхой болгох, тодорхой болгож болдоггүй бол зэрэг гэдэг үгээр солих, эсхүл бүгдийг нь тоочиж бичих	Зэрэг гэдэг үгээр сольсон.
		44 - Кабелийн телевиз - энэ нэр томъёоны тайлбарыг ойлгосонгүй, магадгүй нэг санааг 4 дэх янзаар тайлбарлах гэж оролджээ	Нэр томъёоны тайлбарыг дахин найруулсан.
		45 - Кабелийн үйлчилгээ эрхлэгч гэж кабел зардаг нэг газар байгаа юмаа даа. Маш утгагүй тайлбар байна.	Энэ нэр томъёог хассан.

